

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 03 дугаар сарын 21-ны өдөр

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
	Үүрэг даалгавар НЭГ: “Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үед төрийн байгууллагын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангаж, идэвх санаачилгатай оролцох.			
	<p>Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, ард иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд “Стратегийн команд штабын сургууль”-ийг зохион байгуулахаар бэлтгэж ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>Стратеги команд штабын дадлага сургуулийн хүрээнд дүүргийн Онцгой комиссын гишүүд болон гамшгаас хамгаалах удирдах бүрэлдэхүүнд Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, бригадын генерал Б.Ууганбаяр “Ослын үеийн удирдлагын тогтолцоо-Хариу арга хэмжээ, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах үеийн гамшгаас хамгаалах албадын удирдлагын гүйцэтгэх үүрэг, харилцан ажиллагаа” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 16:00 цагаас 17:30 цагийн хооронд Нийслэлийн Онцгой байдлын газрын Соёлын төвд 1 цаг 30 минутын хугацаанд зохион байгуулав.</p> <p>Тус сургалтад дүүргийн удирдлага, Онцгой комиссын гишүүд, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж байгууллага, хороодын Засаг дарга нар, дүүргийн Онцгой байдлын хэлтсийн офицер алба хаагчдыг хамруулсан бөгөөд сургалтад нийт 149 алба хаагч, албан тушаалтан хамрагдсан.</p>			
	Үүрэг даалгавар ХОЁР: Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд барилгын ажлын гаднах талбайн орчны аюулгүй байдлыг хангуулах, хяналт тавих нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайтар хангаж, хяналт тавьж ажиллах.			
	Дүүргийн хэмжээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд барилгын ажлын гаднах талбайн орчны аюулгүй байдлыг хангуулан барилгын ажил явагдаж буй 4 байршилд хашаа засварлах, орчны бохирдлыг арилгуулах, том оврын ачааны машин холдуулах, явган зам засварлах зэрэг шаардлага хүргүүлэн зөрчлийг арилгуулан ажиллалаа.			

Үүрэг даалгавар ГУРАВ: 2023 оны 03 дугаар сарын 20-ноос 07 дугаар сарын 10-ныг хүртэл “Сүхбаатарын талбай” дээр иргэд, олон нийтэд зориулсан аялал жуулчлал, соён гэгээрүүлэх, нийгэм, соёл урлагийн салбарын арга хэмжээнүүдийг зохион байгуулах, бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.

Дүүргийн Соёлын төвөөс заагдсан хугацаанд “Сүхбаатарын талбай”- д иргэд, олон нийтэд зориулсан аялал жуулчлал, соён гэгээрүүлэх, нийгэм, соёл-урлагийн арга хэмжээний дараах хөтөлбөрийг гарган ажиллаж байна. Үүнд:

1. Хаврын 33 дахь удаагийн “Номын баяр” 2023.05.19-21-ний өдрүүдэд
2. “Автомашингүй өдөр” 05 дугаар сарын 27-ны өдөр
3. “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” 06 дугаар сарын 01-ний өдөр
4. Монголчуудын уламжлалт соёл, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг гадаад, дотоодын иргэд, жуулчдад сурталчлан таниулах “Дээлтэй Монгол” арга хэмжээ 07 дугаар сарын 09-ний өдөр тус тус зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн.

Үүрэг даалгавар ДӨРӨВ: “Digital Ub” буюу Хэсгийн ахлагчийн аппликэйшнг байгууллагуудын ажилтан, албан хаагчдаа танилцуулж хэрэглээг нэмэгдүүлж, цахимжуулах ажлаа эрчимжүүлэн, хэсгийн ахлагчдаас ирүүлсэн зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг шуурхай шийдвэрлэн, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.

Хэсгийн ахлагч нарын цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд 1-24 дүгээр хороодын 215 хэсгийн ахлагч нарт дата эрх бүхий утасны дугаарыг хэсгийн ахлагч нарын нэр дээр үүсгэж, Юнител ХХК-тэй гэрээ байгуулан байгууллагын нэр дээр бүртгэх ажлыг зохион байгуулсан. 1-24 дүгээр хороодын хэсгийн ахлагч нарын 1,2 дугаар сард хийсэн ажлын тайлан цахим системд оруулан үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулж байна.

Мөн Dijital Ub буюу Хэсгийн ахлагчийн аппликэйшнээр хэсгийн ахлагч нараас ирүүлсэн зөрчлийг тухай бүрд нь шийдвэрлэн ажилласан. Дүүргийн 4 дүгээр хорооны хэсгийн ахлагч М.Цэцэгжаргалаас ирүүлсэн **4-р хороо,18 болон 11 байрны авто машины туслах зам сэтэлж, холбооны шугам засвар хийгээд 2022 оны 06-р сараас хойш өнөөдрийг хүртэл засахгүй байна** гэсэн зөрчлийг шийдвэрлэн 2022 оны 07 дугаар сард сэтэлгээ хийж сүлжээний гэмтэл засварлах ажил гүйцэтгэсэн , нөхөн сэргээлтийн ажлыг дутуу хийсэн “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-аар нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийж дуусгах талаар Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд 8/565 тоот албан бичгийг уламжилсан.

Дүүргийн 4 дүгээр хорооны хэсгийн ахлагч Л.Одонтуяагийн ирүүлсэн **Дүүргийн 4-р хороо 122-ийн ойр орчмын хогийг хариуцсан нэгжээр цэвэрлэгээ хийлгэх хүсэлтийг** хүлээн авч 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр цэвэрлэгээг хийлгэж Наши трейд ХХК-р тээвэрлүүлэн ажилласан.

Дүүргийн 5 дугаар хорооны хэсгийн ахлагч Хүрэлсүхийн ирүүлсэн **Хөдөлмөр нийгмийн харилцааны дээд сургуулийн орчим 50м дотор орчин бохир байна. Хэлсэн боловч цэвэрлээгүй байна** гэсэн зөрчлийн дагуу Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсээс 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр цэвэрлэгээг хийлгэн ТҮК-аар тээвэрлүүлсэн.

Үүрэг даалгавар ТАВ: Замын хөдөлгөөний нэгдсэн систем /RFID/ буюу техникийн хяналтын цахим гэрчилгээг иргэдэд олгох, тээврийн хэрэгсэлд суурилуулах байршлуудаа судалж тодорхойлох, зохион байгуулалтын бэлтгэл ажлаа сайтар хангаж, мэргэжлийн чиг үүргийн байгууллагууд дэмжлэг үзүүлж ажиллах.

	Замын хөдөлгөөний нэгдсэн систем /RFID/ буюу техникийн хяналтын цахим гэрчилгээг иргэд, жолооч нарт сурталчлах зорилгоор Замын цагдаагийн хэлтсээс Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтран төлөвлөгөө гарган батлуулж, алба хаагчдыг мэдээ мэдээллээр хангаж төрийн болон төрийн бус байгууллагын алба хаагч, ажилтанд сурталчлан ажилласан.			
Үүрэг даалгавар ЗУРГАА: Дүүргүүд болон төсвийн орлого бүрдүүлэгч агентлаг, харьяа газар, байгууллагууд төсвийн орлогын биелэлтийг жигд хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах.				
	2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар Дүүргийн төсөвт 43,199.2 сая төгрөг төвлөрөхөөс 32,652.8 сая төгрөг төвлөрч 78,5 хувийн биелэлттэй байна. Дүүргийн төсвөөс Нийслэлийн төсөвт 28,935.1 сая төгрөг шилжүүлэхээс 19,290.1 мянган төгрөг шилжүүлж 66,6 хувийн биелэлттэй ажиллаж байна. 2023 оны 1 дүгээр улирлаар Дүүргийн төсвөөс Нийслэлийн төсөвт шилжүүлэх сарын төлөвлөгөө болон Дүүргийн төсөвт төвлөрүүлэх орлогыг өссөн дүнгээр нэмэгдүүлж ажиллана.		Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлуудыг эрчимжүүлж ажиллана.	
Үүрэг даалгавар ДОЛОО: Төлбөр тооцооны цахим системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан “Төсвийн гүйлгээг цахим системээр хяналт тавих” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 13-ны 10. ⁰⁰ цагт Улаанбаатар хотын Хүүхдийн ордонд зохион байгуулах тул байгууллагуудын удирдлага идэвхтэй оролцох.				
	Төлбөр тооцооны цахим системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан “Төсвийн гүйлгээг цахим системээр хяналт тавих” сэдэвт сургалтанд 2023 оны 03 дугаар сарын 13-ны 10. ⁰⁰ цагт Улаанбаатар хотын Хүүхдийн ордонд, 13. ⁰⁰ -17. ⁰⁰ цагийн хооронд Хангарьд ордонд тус тус зохион байгуулагдсан ба Санхүү, Төрийн сангийн ахлах мэргэжилтэн Б.Оюун, Банкны төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн Б.Туяа, У.Саранзаяа нар сургалтанд хамрагдсан.		“Төсвийн гүйлгээг цахим системээр хянан баталгаажуул ах ажлын бэлтгэл ажлыг хангаж байна.	

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.ЭНХГЭРЭЛ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Т.ТҮВШИНЖАРГАЛ